

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны үеэр  
Засаг даргын өгсөн үүрэг даалгавар

2023.01.31

Багануур дүүрэг

№	Товч агуулга	Хяналт тавих байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>			
1	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай” А/32 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах	СТСХ	ТНААХ
2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/47 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх.	СТСХ	Татварын хэлтэс
3	Нийслэлийн хэмжээнд төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр үл хөдлөх хөрөнгийн татварын орлого, бусад орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх, татварын орлогын бааз суурийг өргөжүүлж санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.	СТСХ	Татварын хэлтэс
4	“Хот хөгжлийн индекс” хэрэгжүүлэхтэй холбогдуулан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран ажиллаж, шаардлагтай судалгаа, мэдээ мэдээлэл шуурхай солилцож, ажлаа уялдуулж ажиллах.	НХХ	Холбогдох байгууллагууд
5	Нийслэлийн хэмжээнд Сар шинийн баярын үзэсгэлэн худалдаа болон Ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхэлж байгаа холбогдуулан иргэд, хүүхэд, багачуудын амгалан тайван байдлыг хангах, хулгайн болон бусад төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулах ажлуудаа эрчимжүүлэх.	НХХ	Цагдаагийн хэлтэс Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс

6	Ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхэлж байгаатай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн хамрагдалтын тоон мэдээлэл болон боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлын явц гэх мэт шаардлагатай мэдээ, мэдээллээр дүүргийн Засаг дарга нарыг хангаж, цаашид хамтран ажиллах.	НХХ	Боловсролын хэлтэс
7	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, цаашид урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулж танилцуулах	НХХ	Эрүүл мэндийн төв
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>			
8	Тайлан сэтгүүл хэвлэгдэхтэй холбоотой холбогдох мэдээллийг яаралтай өгч дуусгах	ТЗУХ	НХХ СТСХ ТНААХ ХХҮХ ЦШ
9	Нохой муурын устгалын ажлыг зохион байгуулах	ТНААХ	Багануур тохижилт ААТҮГ
10	Сар шинийн үзэсгэлэн худалдааг 2-р сарын 5-наас эхлүүлэн Соёлын ордон, Эм Жи төвийн гадна талбайд зохион байгуулах	ХХҮХ	Холбогдох байгууллагууд
11	Нийслэлээс олгосон сургуулийн автобусыг дахин 2-оор нэмэгдүүлж, гэр хорооллын 3 чиглэлд үйлчлэх бэлтгэл ажлыг хангах	ТНААХ	НХХ Боловсролын хэлтэс

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР